

Залилан, Авлига, Хээл хахуулийн эсрэг бодлого

Захирамж, 2/2020

Хамгийн сүүлд хийсэн нэмэлт
өөрчлөлтийг баталсан огноо

24/09/2020

Сүүлд нэмэлт өөрчлөлт оруулсан

Анна Волфова

Баталсан (Үйл явцын шийдвэр
гаргагч)

Якуб Личка

Гарын үсэг

Баримт бичиг эзэмшигч

Үйл явцын менежер

Боломжтой хэл

Чех

Англи

Талархал

Энэхүү баримт бичиг нь
Трокейр (Каритас Ирланд)-ийн ижил
төстэй
Залилан, Авлига, Хээл хахуулийн
эсрэг бодлогыг үндэслэн
боловсруулсан хувилбар болно.

КЧР нь Трокейр дахь Каритаст
тус байгууллагын Залилан, Авлига,
Хээл хахуулийн
эсрэг бодлогыг боловсруулахад
дэмжлэг
Туслалцаа үзүүлсэнд талархаж
байна

1 Зорилго

Каритас Чех Републик нь КЧР-ийн өмнөөс үйл ажиллагаа явуулж буй ажилтан, гэрээт гүйцэтгэгч, дадлагажигч, сайн дурын ажилтан болон бусад гуравдагч этгээдийн зүгээс залилан, авлига, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчил гаргах явдлыг үл тэвчдэг. Энэхүү баримт бичгийн зорилго нь зохисгүй үйлдлийн янз бүрийн арга хэлбэрийн талаар танилцуулж, КЧР-ийн ажилтнууд (удирдах зөвлөл, удирдлага, ажилтнууд, сайн дурынхан болон дадлагажигчдыг хамруулан) болон бусад холбогдох гуравдагч этгээд (үүнд бусдаас гадна гэрээт гүйцэтгэгч нарыг хамруулан) нарт залилан, авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх үүднээс үүрэг хариуцлагыг тодорхойлоход оршино. Залилан, авлига, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчил гарч байгаа тухай мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх, тайлагнах, архивлах үйл явцыг Санал гомдол барагдуулах механизмд болон Шүгэл үлээх механизмд тусгасан болно.

2 Хамрах хүрээ

Энэхүү бодлого нь КЧР-ийн нэрийн өмнөөс Чех улсад болон гадаад дахь офист үйл ажиллагаа явуулж буй КЧР-ийн бүх Захирлуудын зөвлөл, ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчид, дадлагажигч, сайн дурын ажилтнууд болон бусад гуравдагч этгээдийг хамарсан болно. Энэ бодлогод зохисгүй үйлдлүүд гэж Бүгд Найрамдах Чех Улс эсвэл тухайн улс орны шилдэг туршлага, хууль тогтоомжийн дагуу тодорхойлж авч үзсэн.

2.1 Түнш байгууллагууд

Хэдийгээр түнш байгууллагууд энэ бодлогын хүрээнд шууд хамрагдахгүй боловч, КЧР нь түнш байгууллагуудыг сэжиг бүхий луйвар, залилан, авлига, хээл хахууль, мөнгө угаах ба терроризмыг санхүүжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зохистой арга хэмжээ авахыг шаарддаг. Ингээгүй тохиолдолд КЧР-тай хийсэн хамтран ажиллах хэлэлцээрийг цуцлахад хүргэнэ¹. Түнш байгууллагууд нь КЧР-ийн хөрөнгө, үйл ажиллагаатай холбоотой сэжигтэй тохиолдлуудын талаар мэдээлэх үүрэгтэй. КЧР нь түнш байгууллагуудаас КЧР эсвэл бусад холбогдох талууд (өөрөөр хэлбэл, хандивлагчид) -ын зүгээс залилан, авлига, хээл хахууль, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээлэл/сэжигтэй холбоотой аливаа мөрдөн байцаалт, шийдвэрлэх журмыг дэмжин туслалцаа үзүүлэхийг шаарддаг.

¹ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх түншүүдийн үүрэг хариуцлагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хамтран ажиллах тухай гэрээний загварт тусгасан болно.

Хувилбар 24/09/2020

3 Тодорхойлолт

3.1 Залилан ба авлига

Энэхүү бодлогын хүрээнд залилан, авлига гэдэгт дараах зүйлийг хамруулах бөгөөд энэ нь үүгээр хязгаарлагдахгүй:

- КЧР-ийн хөрөнгийг хулгайлах, завших.
- Төлбөр, нөхөн төлбөр хийлгэхээр хуурамч нэхэмжлэл гаргах.
- Төлбөрийн нотолгоо баримт, нэхэмжлэх эсвэл төлбөртэй холбогдсон бусад баримт бичгийг хуурамчаар үйлдэх.
- Хээл хахууль хүлээн авах, санал болгох, эсхүл бэлэг, бусад давуу талыг хүлээн авах нь тухайн бэлэг эсвэл давуу талыг КЧР-д үйлчлэх явцад нь ажилтны шийдвэр гаргахад нөлөөлөх зорилготой үйлдсэн байж болзошгүй гэж үзвэл.
- Гуравдагч этгээдээс орлогын хувь комисс авах эсвэл түүнд хувь төлөх.
- КЧР-ийн сангаас санхүүгийн болон бусад ашиг олох зорилгоор гуравдагч этгээд, түүний дотор ханган нийлүүлэгчид, түнш байгууллагуудтай тохиролцох.
- Айлган сүрдүүлэх, сүрдүүлгээр мөнгө салгах.
- Нягтлан бодох бүртгэлээс гадуур тооцоо хөтлөх эсвэл хуурамч, зохиомол бичилт хийх.
- Санаатайгаар худал хуурамч эсхүл төөрөгдүүлсэн санхүүгийн тайлан гаргах ба/эсхүл түгээх.
- Хувийн ашиг олох зорилгоор эсхүл КЧР-д хохирол учруулах зорилгоор КЧР-ийн журмыг (тухайлбал, Худалдан авалтын гарын авлагыг) зөрчих.
- КЧР-ийн материаллаг ашиг сонирхолд хохирол учруулах зорилгоор санаатайгаар хайхрамжгүй цалгар хандлага гаргах.
- КЧР-ын ашиг сонирхлын эсрэг гутамшигтай, хариуцлагагүй, санаатай үйлдэл хийх.
- Хууль бус, ёс суртахуунгүй болон/эсхүл хэн нэгний ажлын үүрэг, үүрэг хариуцлага эсхүл бусдын эрхэд нийцсэн аргаар давуу эрх олгох буюу олж авах.

3.1.1 Мөнгө угаах ба терроризмыг санхүүжүүлэх²

КЧР нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх явдалд тэг хүлцэл үзүүлэн, үл тэвчих тал дээр шийдэмгий байдаг, тухайлбал:

² Энэхүү бодлого нь Бүгд Найрамдах Чех Улсын Дотоод хэргийн яамны [Riziko zneužití nestátních neziskových organizací pro účely financování terorismu či praní peněz](#) удирдамжтай нийцнэ.

эд хөрөнгө, санхүүгийн нөөцийг эрүүгийн үйл ажиллагаанаас үүдэлтэй гэдгийг мэдсээр байж, олж авах, эзэмших, шилжүүлэх, ашиглах хууль бус хөрөнгийг хууль ёсны мэт харагдуулах үйлдэл террорист үйл ажиллагаа, террористууд болон террорист байгууллагыг³ хууль ёсны эсхүл хууль бус эх үүсвэрээс санхүүжүүлэх

3.2 Хээл хахууль

Дараах зүйл бол хээл хахуультай холбогдсон тодорхойлолтууд юм:

- Бусад хүнд хээл хахууль өгөх нь тухайн хүнийг холбогдсон чиг үүргийг хэрэгжүүлэхэд эсхүл зохисгүй үйлдэл хийхэд өдөөх зорилгоор шагнал өгөхөөр санал болгох, амлах, өгөхийг хэлнэ.
- Хээл хахууль авсан гэж 'холбогдсон чиг үүргийг' гүйцэтгэсэн эсвэл зохисгүй үйлдэл хийснийхээ хариуд шагнал хүлээн авахыг зөвшөөрөх эсвэл шагнал хүсэхийг хэлнэ.
- Гадаадын төрийн албан тушаалтанд хээл хахууль өгнө гэж төрийн албан тушаалтанд нөлөөлөхийг зөвшөөрөөгүй эсхүл хуулиар шаардлагатай гэж үзээгүй нөхцөл байдалд бизнес эрхлэх, хадгалах зорилгоор гадаадын төрийн албан тушаалтанд нөлөөлөхийг оролдсон нь тодорхой зөрчлийг хэлнэ.
- Хөнгөвчлөх төлбөр гэж албан тушаалтнуудыг хийх үүрэгтэй ердийн чиг үүргээ гүйцэтгэхэд нь урамшуулах явдал бөгөөд ингэхийг хээл хахууль гэж үзнэ.
- Хээл хахуулиас урьдчилан сэргийлж чадаагүй нөхцөл байдал нь тухайн байгууллага түүний нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж буй хүмүүсийг хээл хахуульд холбогдохыг зогсоож чадаагүй тохиолдолд гардаг. Үүнд байгууллагын нэрийн өмнөөс ажилладаг хүмүүсийн үйл ажиллагаа хамрагдана, жишээлбэл, ажилтан, зөвлөх эсхүл бусад гуравдагч этгээд, хэрэв тухайн байгууллага бизнес эрхлэх, хадгалахад хүргэхийн тулд энэ хүмүүс хээл хахууль авах, өгөхөд холбогдсон бол.

3.3 Ашиг сонирхлын зөрчил

Худалдан авалт хийх эрх мэдэл бүхий томилогдсон КЧР-ийн ажилтнууд эсхүл гэрээт гүйцэтгэгчид эсхүл менежментийн албан тушаал томилогдсон хүмүүс ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх ёстой, тухайлбал:

3 Тeррорист үйлдлүүд, террористууд болон террорист байгууллагууд гэдгийн нэмэлт тодорхойлолтыг НҮБ-ын [Тeрроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх Олон Улсын Конвенцоос](#) үзэж болно.

4

Хувилбар 24/09/2020

Ажилтан, гэрээт гүйцэтгэгч, сайн дурын ажилтан эсхүл дадлагжич нарын мэргэжлийн үүргээ гүйцэтгэх болон хувийн, санхүүгийн, улс төрийн эсхүл гэр бүлийн ашиг сонирхлын хооронд сэжиг төрүүлэхүйц зөрчилтэй байж болохгүй.

Худалдагчдаас эсхүл боломжит борлуулагчдаас мөнгөний үнэ цэнэтэй зүйлийг хэн ч шууд эсхүл шууд бус хэлбэрээр хүсэж, авахыг хүлээн зөвшөөрч болохгүй. КЧР-ийн нэрийн өмнөөс хүлээн авсан 2 000 CZK (~ 70 EUR) хүртэлх үнэтэй төлөөллийн бэлэг авахаас бусад тохиолдолд хэн ч ямар ч бэлэг хүлээн авахыг зөвшөөрч болохгүй.

Эдгээр бэлгүүдийн талаар шугамынхаа менежерт мэдэгдэх ёстой.

КЧР-ийн ажилтан эсхүл КЧР-ийн ажилтны хамаатан садны өмчлөл, хяналт, идэвхтэй нөлөөлөлд байдаг аливаа компаниас тендерийн санал авч болохгүй бөгөөд гэрээ байгуулахыг зөвшөөрч болохгүй.

Энэ жагсаалт нь үүгээр дуусахгүй.

Хэрэв ямар нэгэн тохиолдолд ажилтнууд эсвэл дээр дурдсан бусад гуравдагч этгээд ашиг сонирхлын зөрчилтэй байж болох, ойлгомжгүй байдалд орсон бол ахлах менежерүүдтэйгээ (Газрын дарга эсхүл гадаадад Төлөөлөгчийн газрын тэргүүнтэй) зөвлөлдөх ёстой бөгөөд КЧР-ийн нэр хүнд, эд хөрөнгийг хамгаалахад хамгийн зохистой арга хэмжээг авна.

4 Илрүүлэх, урьдчилан сэргийлэх, мэдээлэх үүрэг хариуцлага

Бүх түвшний ажилтнууд болон бусад дурдагдсан гуравдагч талууд нь залилан, авлига, хээл хахуулийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэхийн тулд хичээнгүй анхааралтай хандах үүрэгтэй. Энэ үүрэг хариуцлагад уг Бодлогыг зөрчсөн шинж тэмдэг илэрсэн эсэхэд сэрэмжтэй байх явдал хамрагдана. Ажилтнууд залилан мэхлэх, авлига, хээл хахууль авах боломжийн талаар сэрэмжтэй байх ёстой бөгөөд зохисгүй, шударга бус үйл ажиллагаа явагдаж байгаа талаар сэрэмжтэй ёстой.

ТУЗ-ийн бүх гишүүд, менежерүүд, Төлөөлөгчдийн газрын тэргүүн, санхүүгийн зохицуулагч нар ажлын байранд болон офисын байршилд тохиолдож болох аливаа зохисгүй байдлын талаар

/ мэддэг байх үүрэгтэй. Энэ үүрэг хариуцлагад уг бодлогыг зөрчсөн байж болох талаар дотоод шалгалт хийх хамрагдана.

Энэ үүрэг хариуцлагаа биелүүлээгүй хүмүүст КЧР-ийн сахилгын журмын дагуу ажил/гэрээг цуцлах хүртэл засаж залруулах арга хэмжээ авах болно.

5 Лавлагаа баримт бичиг

Ёс зүйн дүрэм

Хувилбар 24/09/2020

Зан байдлын дүрэм

Санал гомдол барагдуулах механизм

Шүгэл үлээх механизм

Ажиллах нөхцөл/Ажилтнуудын зохицуулалт

Худалдан авалтын гарын авлага

Аюулгүй байдлын гарын авлага

6 Товчлолын жагсаалт

КЧР

Каритас Чех Републик

7 Хавсралтын жагсаалт

Ашиг сонирхлын хүүг үзүүлэх загвар